



БУЛГАН АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



**ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА**

2019 он

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

М.МӨНХБАТ

ХЭЛСТИЙН ДАРГА

ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛСАН:

Ц.БАТЧИМЭГ

МЭРГЭЖИЛТЭН

БУЛГАН АИМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Монгол улс, Булган аймаг
Лхагвадоржын гудамж, 5-р баг
Аймгийн нутгийн удирдлагын ордон
Өрөө 106 тоот
Утас: 70342766
N-мэйл: bulgan@nso.mn
Интернет хаяг: www.bulgan.nso.mn

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	3
Хавсралтын жагсаалт	4
Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	6
Оршил.....	8
Мал тооллогын товч түүх.....	9
I. МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	10
Малтай өрх, малчин өрхийн тоо.....	10
Малчин өрхийн ам бүл.....	11
Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлт	12
II. МАЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ	13
Малчдын тоо	13
Малчдын нас, хүйс	13
Үндсэн болон туслах малчин.....	14
Малчдын боловсролын түвшин.....	14
Малчдын гэрлэлтийн байдал	15
Малчдын нийгмийн даатгалд хамрагдсан байдал.....	16
Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал.....	16
Малчдын гар утас болон интернетийн хэрэглээ	16
III. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ	17
Малын тоо	17
Улсын болон хангайн бүсэд Булган аймгийн мал сүргийн эзлэх хувь.....	19
Малын тоогоор тэргүүлсэн сумд.....	19
Амины малын тоо.....	20
Малтай өрхийн бүлэглэлт.....	21
Малчин өрхийн бүлэглэлт.....	21
Сүргийн бүтэц.....	22
Хээлтэгч мал.....	23
Төл бойжилт.....	24
Хээл хаялт, сувайралт.....	25
Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.....	26
Малын хэрэглээний зарлага.....	27
Том малын зүй бусын хорогдол.....	27
Тэжээвэр амьтад.....	28
Цэвэр үүлдрийн болон эрлийз мал.....	29
IV. ГАЗАР ТАРИАЛАН.....	30
Тариалсан талбай, өрх аж ахуй нэгж байгууллага.....	30
Тариалсан талбай.....	30
Хураасан ургац.....	33
Га-гийн ургац.....	35
Хүлэмжийн тариалалт.....	37

Дүгнэлт.....	38
V. ХАВСРАЛТ.....	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Улсын болон хангайн бүсэд Булган аймгийн малчдын эзлэх хувь.....	10
Хүснэгт 2. Малтай өрхийн тоо.....	10
Хүснэгт 3. Малчин өрхийн тоо.....	11
Хүснэгт 4. Малчин өрх, малчин өрхийн ам бүл, нэг өрхөд ногдох малын тоо	12
Хүснэгт 5. Малчдын соёл ахуйн үзүүлэлт	12
Хүснэгт 6. Малчин өрхийн зарим үзүүлэлт, сумаар.....	12
Хүснэгт 7. Малчдын тоо.....	13
Хүснэгт 8. Малчдын насны бүлгээр	13
Хүснэгт 9. Малчдын боловсролын түвшин.....	14
Хүснэгт 10. Малчдын гэрлэлтийн байдал, насны бүлгээр.....	15
Хүснэгт 11. Мал, тэжээвэр амьтдын тоо.....	17
Хүснэгт 12. Малын тоо, төрлөөр, бод, хонин толгойд шилжүүлснээр, сумаар.....	17
Хүснэгт 13. Улсын болон хангайн бүсэд мал сүргийн эзлэх хувь.....	19
Хүснэгт 14. Амины малын тоо, төрлөөр, сумаар	20
Хүснэгт 15. Малтай өрхийн бүлэглэлт, малын тооны бүлгээр	21
Хүснэгт 16. Малчин өрхийн бүлэглэлт, малын тооны бүлгээр.....	22
Хүснэгт 17. Нэг малчин өрхөд ногдох малын тоо, сумаар	22
Хүснэгт 18. Сүргийн бүтэц.....	23
Хүснэгт 19. Хээлтэгч малын тоо.....	24
Хүснэгт 20. Бойжуулсан төл, сумаар, төрлөөр.....	24
Хүснэгт 21. 100 эхээс бойжуулсан төл, төрлөөр.....	25
Хүснэгт 22. Хээл хаясан хээлтэгч	25
Хүснэгт 23. Сувайрсан хээлтэгч	26
Хүснэгт 24. Төл өгөөгүй хээлтэгч	26
Хүснэгт 25. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо	26
Хүснэгт 26. Малын хэрэглээний зарлага	27
Хүснэгт 27. Том малын зүй бус хорогдол.....	27
Хүснэгт 28. Оны эхний малд эзлэх хувь	27
Хүснэгт 29. Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо.....	27
Хүснэгт 30. Өвчнөөр хорогдсон малын тоо	28
Хүснэгт 31. Тэжээвэр амьтад.....	28
Хүснэгт 32. Цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн сайжруулсан малын тоо	29
Хүснэгт 33. Малын тэжээл.....	29
Хүснэгт 34. Тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж байгууллага, сумаар.....	30
Хүснэгт 35. Тариалсан талбай, ургамлын төрлөөр.....	30
Хүснэгт 36. Нийт тариалсан талбай, сумаар.....	31
Хүснэгт 37. Тариалсан талбай, ургамлын төрлөөр, оноор.....	32
Хүснэгт 38. Усалгаатай талбайн тариалалт, сумаар.....	32
Хүснэгт 39. Усалгаатай талбайн тариалалт, өрх аж ахуй нэгж байгууллагаар.....	33
Хүснэгт 40. Хураасан ургац, ургамлын төрлөөр.....	33
Хүснэгт 41. Хураасан ургац, өрх, аж ахуй нэгж байгууллагаар.....	33
Хүснэгт 42. Өрхийн хураасан ургац, сумаар, ургамлын төрлөөр.....	34
Хүснэгт 43. Аж ахуй нэгж, байгууллагын хураасан ургац, сумаар.....	34

Хүснэгт 44. Га-гийн ургац, ургамлын төрлөөр.....	35
Хүснэгт 45. Хураасан ургац, тариалсан талбай, га-гийн ургацын дээд хэмжээ.....	35
Хүснэгт 46. Га-гаас хураасан үр тариа, төмсний ургац.....	36
Хүснэгт 47. 2019 оны ургац хураалтыг 2018 оныхтой харьцуулсан байдал.....	36
Хүснэгт 48. Хүлэмжийн тариалалт, өрх аж ахуй нэгж байгууллагаар.....	37
Хүснэгт 49. Хүлэмжийн ургац, хураалт, сумаар.....	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Малчин өрх, мал бүхий өрхийн тоо.....	11
Зураг 2. Малчдын насны бүтэц, хувиар	14
Зураг 3. Үндсэн болон туслах малчны харьцаа	14
Зураг 4. Малчдын эзлэх хувь, гар утастай малчдын эзлэх хувь, насны бүлгээр	17
Зураг 5. Малын тоо, сумаар, 2019.....	18
Зураг 6. Малын тоо, сумаар, 2018.....	18
Зураг 7. Малын тоо, өсөлт, бууралт, хувиар	18
Зураг 8. Хамгийн их адуу тоолуулсан 5 сум	19
Зураг 9. Хамгийн их үхэр тоолуулсан 5 сум	19
Зураг 10. Хамгийн их тэмээ тоолуулсан 5 сум	20
Зураг 11. Хамгийн их ямаа тоолуулсан 5 сум	20
Зураг 12. Хамгийн их хонь тоолуулсан 5 сум	20
Зураг 13. Хамгийн их мал тоолуулсан 5 сум.....	20
Зураг 14. Сүргийн бүтэц.....	23
Зураг 15. Гарсан төл, бойжсон төл, хорогдсон төл.....	25
Зураг 16. Том малын зүй бус хорогдол, сумаар.....	28
Зураг 17. Нийт болон үр тариа тариалсан талбай, га.....	31
Зураг 18. Үр тарианы га-гийн ургац, центнерээр.....	36

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Малтай өрхийн бүлэглэлт, сумаар	40
Хүснэгт 2. Малчин өрхийн бүлэглэлт, сумаар.....	40
Хүснэгт 3. Малчин өрхийн тоо.....	41
Хүснэгт 4. Нэг малчин өрхөд ногдох малын тоо, сумаар	41
Хүснэгт 5. Малтай өрхийн тоо, сумаар	41
Хүснэгт 6. Сүргийн бүтэц, сумаар	42
Хүснэгт 7. Тэмээн сүргийн бүтэц, сумаар.....	42
Хүснэгт 8. Адуун сүргийн бүтэц, сумаар.....	43
Хүснэгт 9 Үхэр сүргийн бүтэц, сумаар	43
Хүснэгт 10 Хонин сүргийн бүтэц, сумаар.....	44
Хүснэгт 11. Ямаан сүргийн бүтэц, сумаар.....	44
Хүснэгт 12. Хээлтэгч мал, сумаар.....	45

Хүснэгт 13. Нийт сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь, сумаар.....	45
Хүснэгт 14. Төллөсөн хээлтэгч.....	45
Хүснэгт 15. Төллөлтийн хувь, сумаар.....	46
Хүснэгт 16. Гарсан төл, сумаар.....	46
Хүснэгт 17. Хорогдсон төл, сумаар.....	47
Хүснэгт 18. Төл бойжилтын хувь, сумаар.....	47
Хүснэгт 19. Хээл хаясан хээлтэгч, сумаар.....	47
Хүснэгт 20. Сувайрсан хээлэгч, сумаар.....	48
Хүснэгт 21. Хээлтүүлэгчийн тоо, сумаар.....	48
Хүснэгт 22. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо, сумаар.....	49
Хүснэгт 23. Хүнсэнд хэрэглэсэн малын тоо, сумаар.....	49
Хүснэгт 24. Зах зээлд борлуулсан малын тоо, сумаар.....	50
Хүснэгт 25. Том малын зүй бус хорогдол, сумаар.....	50
Хүснэгт 26. Том малын зүй бус хорогдол оны эхний малд эзлэх хувь, сумаар.....	50
Хүснэгт 27. Гэнэтийн аюулаах хорогдсон малын тоо, сумаар.....	51
Хүснэгт 28. Өвчнөөр хорогдсон малын тоо, сумаар.....	51
Хүснэгт 29. Гахайн тоо, сумаар.....	52
Хүснэгт 30. Шувууны тоо, сумаар.....	52

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр - 1 бод

1 тэмээ - 1.5 бод

6 хонь - 1 бод

8 ямаа - 1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь

1 адуу - 7 хонь

1 үхэр - 6 хонь

1 хонь - 1 хонь

1 ямаа - 0.9 хонь

Төл мал :Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана. Харьцангуй үзүүлэлтийг гарахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25

Азарга - 12-15

Бух - 35-45

Хуц, ухна - 25-30

Малын зүй бусын хорогдолд: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол гэнэтийн аюулын (цас зуд, үер, ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол бусад

шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын (хонь, ямааны) тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд: Хадлан өвс 0.45, Таримал тэжээл 0.35, Даршны ургамал 0.25, Гар тэжээл, хужир шүү 1.00, Төмс ногооны хаягдал 0.22, Үр тарианы хаягдал 0.90, Лай 0.40, Сүрэл 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна. Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

Бүдүүн тэжээл-өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.

Хүчит тэжээл-үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.

Шүүст тэжээл-Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно. Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

ОРШИЛ

Дэлхийн олон улс орны нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм. Мал аж ахуй салбар эдийн засгийн тулгуур, үндсэн гол салбар байж, ДНБ-ий 53.4 хувийг хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэж байна.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2019 оны төлөв байдлыг нэгтгэн тусгав.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай ” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 11-р сарын 25-ны өдрийн А/549 тоот захирамжийн дагуу Булган аймгийн Статистикийн хэлтэс нь мал, тэжээвэр амьтад, хашаа, худаг, тэжээлийн тооллогыг 2019 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулав.

Мал тэжээвэр амьтдын тооллогын дүнд үндэслэж, мал амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлт, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний хэмжээг тооцон дүн шинжилгээ хийж, цаашид хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төр засгийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг дүгнэхэд шаардагдах дэлгэрэнгүй мэдээллийг гарган авх, салбарын эдийн засгийн тооцооны тулгуур үндэслэл болдогоороо ихээхэн ач холбогдолтой юм.

Энэхүү танилцуулгад мал тооллогын 2019 оны дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, малчин өрх, малчдын мэдээлэл, мал эмнэлгийн арга хэмжээ, малын хашаа зэрэг мэдээллийг 2019 оны жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Булган аймгийн тэргүүлэх салбар болох мал аж ахуйн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ нь орон нутгийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт тусгагдсан хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд бодлого боловсруулагч, хэрэглэгч та бүхний хэрэгцээ шаардлагыг хангасан суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.

МАЛ ТООЛЛОГЫН ТОВЧ ТҮҮХ

Мал аж ахуй нь Монгол орны хувьд амьжиргааны гол эх үүсвэр болсон анхдагч үйлдвэрлэлийн салбар байсны хувьд бүртгэл, статистикийн ажил ч энэ салбараас эхлэн хөгжсөн түүхтэй. XIII зууны үед Монгол улсад хүн, малын тооллого явуулж байсан баримт түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Манжийн хараат байх үед Монголд мал тооллого явуулж байсан боловч нэгдсэн тооллого хийж чаддаггүй, орон нутгийн чанартай байв. Аймаг, хошуудад янз бүрийн хугацаанд, өөр өөрсдийн шаардлага үзэмжээр мал тооллого явуулж байсан байна.

Гадаад Монголын Засгийн газар 1918 онд хүн ам, малын тооллого явуулсан байна. Уг тооллого нь халхын 4 аймаг, лам, ноёд, шавь албат ардууд, сүм хийдийн малыг хамруулсан боловч Ховдын хязгаар, Дархадын хязгаар, Хөвсгөл нуур орчмын Богд гэгээний эзэмшил нутгийн мал ороогүй ажээ.

Ардын засгийн газар 1924 онд Дотоод яамны бүтцэд Тоо бүртгэлийн хэлтсийг шинээр байгуулж, мал тооллогыг үнэн зөв явуулах талаар онцгой анхаарч, тооллого явуулах, данс бүртгэлийг нэгтгэх, тушаах цаг хугацааг тогтоож, хуучин төлөөний түшмэл дээр боловсрол чадвартай тусгай түшмэлийг нэмж томилж, ард олонд тайлбарлан таниулах ажлыг зохиосны үр дүнд анх удаа улсын хэмжээгээр хугацаа, аргачлалын хувьд нэгдсэн программтай мал тооллого явагдсан байдаг.

Мал тооллогод урьд өмнө нт бүртгэгдэхгүй байсан цаа, буга, луус, өвс хадлан, тариалангийн талаар зарим нэмэлт үзүүлэлтийг 1924 оноос эхлэн оруулсан байна. Мал тооллогыг зун, намрын улиралд буюу ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байсан бол, 1961 оноос эхлэн мал, тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болсон. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого, зарлагын үзүүлэлт бүрэн дууссан, малчид өвөлжөөндөө бууж, хүн малын хөдөлгөөн харьцангуй бага байдаг зэрэг давуу талтай юм.

Малын хашаа байрын тооллогыг 1966 оноос, худаг, малын тэжээлийн тооллогыг 1972 оноос нэмж мал тооллоготой хамтруулан явуулдаг болов.

Ардын хувийн аж ахуйтны малыг 1959-1960 онд нийгэмчилж, хоршоололд хамруулж дууссан бол 1992 онд малыг хувьчлах ажил хийгдэж дууссан билээ.

Сүүлийн жилүүдийн тооллого нь малчдын мэдээлэл, эрчимжсэн мал аж ахуйн мэдээлэл, бэлтгэсэн хадлан, тэжээл аргал, хөрзөн, түлшний мод, малчин өрхийн зарим мэдээллийг дэлгэрэнгүй тусгаж өгснөөрөө өмнөх тооллогуудаас илүү онцлог, ач холбогдолтой болсон.

Мал хувийн өмчид шилжсэнээр улсын хэмжээнд төлөвлөгөөт эдийн засгийн үед жилд дунджаар 23 сая.толгойгоос хэтрэхгүй байсан малын тоо 2019 оны байдлаар 70.9 сая.толгойд хүрээд байна.

**МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХ, ТЭДГЭЭРИЙН
СОЁЛ, АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Малтай өрх, малчин өрхийн тоо

2000 оноос хойших 19 жилийн хугацаанд малчин өрхийн тоонд гарсан өөчлөлтийг авч үзвэл, 2001-2005 онд жилд дунджаар 1.4 мянган өрхөөр, 2008-2013 онд жилд дунджаар 0.4 мянган өрхөөр буурч байжээ. Тухайлбал, 2005 онд 6.4 мянган малчин өрхтэй болсон нь 2000 оноос хойших хугацаанд хамгийн бага түвшинд хүрсэн юм. Үүнд 2009-2010 онд зуд болж, зудын эрсдэлийн улмаас малчдын амьжиргааны гол эх үүсвэр болсон мал хамгийн их хэмжээгээр буюу 223.8 мянгаар хорогдсон нь голлон нөлөөлсөн байна. Малчин өрх 2010 онд өмнөх оныхоос 0.3 мянгаар, 2011 онд 0.2 мянгаар, 2012 онд 0.1 мянгаар буурч байжээ. Харин 2013-2017 онд малчин өрх жилд дунджаар 0.4 мянгаар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2019 онд 171.6 мянга, хангайн бүсэд 69.9 мянган малчин өрх байна. Малчин өрх нь жилийн 4 улиралд малаа маллаж ашиг шимийг нь авч, амьжиргааны эх үүсвэр болгож буй малчин өрх юм. Нийт малчин өрхийн 5.0 хувийг, хангайн бүсийн 12.2 хувийг манай аймаг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. УЛСЫН БОЛОН ХАНГАЙН БҮСЭД БУЛГАН АЙМГИЙН МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Аймгийн нэр	2015	2016	2017	2018	2019
	мянга.өрх				
Улсын дүн	153.09	160.65	169.74	169.71	171.61
Хангайн бүс	63.01	65.39	69.11	69.12	69.92
Архангай	14.13	14.44	15.16	14.98	15.24
Баянхонгор	10.61	11.17	11.82	11.92	12.01
Булган	8.06	8.3	8.50	8.30	8.53
Орхон	0.77	0.81	0.88	0.86	0.84
Өвөрхангай	14.66	15.41	16.09	16.31	16.40
Хөвсгөл	14.79	15.27	16.66	16.76	16.91
	12.8	12.7	12.3	12.0	12.2
Хангайн бүсийн дунд Булган аймгийн малчдын эзлэх хувь					
Улсын дүнд Булган аймгийн малчдын эзлэх хувь	5.3	5.4	5.0	4.9	5.0

Аймгийн хэмжээгээр 2019 оны мал тооллогын дүнгээр малтай өрхийн тоо 10.7 мянга болсон нь өмнөх оноос 1 хувиар, малчин өрхийн тоо 3 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 2. МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, сумаар


Сумын нэр	2015	2016	2017	2018	2019
Булган	376	399	430	390	393
Баян-Агт	693	716	730	730	735
Баяннуур	382	384	374	368	388
Бугат	497	509	529	543	536
Бүрэгхангай	618	633	630	627	649
Гурванбулаг	746	767	756	756	758
Дашинчилэн	562	584	577	578	584
Могод	753	751	750	763	770
Орхон	904	905	901	890	884
Рашаант	614	653	671	669	672
Сайхан	959	962	936	924	925

БУЛГАН АИМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУИН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

Сэлэнгэ	534	562	579	584	593
Тэшиг	589	585	585	588	587
Хангал	614	632	638	653	649
Хишиг-Өндөр	611	635	652	639	641
Хутаг-Өндөр	885	937	947	981	978
Дүн	10337	10614	10685	10683	10742

2019 оны мал тооллогын дүнгээр Бүрэгхангай сумын малчин өрхийн тоо 861 болж өмнөх оноос 16 хувиар, Булган сумын малчин өрхийн тоо 275 болж 14 хувиар өссөн нь хамгийн их, Хишиг-Өндөр сумын малчин өрхийн тоо 456 болж 6 хувиар буурсан байгаа нь хамгийн их байна.

ЗУРАГ 1. МАЛЧИН ӨРХ, МАЛ БҮХИЙ ӨРХИЙН ТОО



ХҮСНЭГТ 3. МАЛЧИН ӨРХИЙН ТОО, сумаар

Сумын нэр	2015	2016	2017	2018	2019
Булган	279	292	299	241	275
Баян-Агт	594	588	645	618	619
Баяннуур	304	307	293	286	304
Бугат	416	428	484	501	514
Бүрэгхангай	493	505	463	440	511
Гурванбулаг	584	596	572	528	521
Дашинчилэн	367	379	359	351	366
Могод	485	508	587	579	611
Орхон	806	840	838	824	817
Рашаант	527	541	531	506	529
Сайхан	832	847	842	823	812
Сэлэнгэ	281	297	314	323	336
Тэшиг	450	461	463	466	504
Хангал	437	440	479	466	487
Хишиг-Өндөр	427	448	499	483	456
Хутаг-Өндөр	775	824	831	861	852
Дүн	8057	8301	8499	8296	8514

Малчин өрхийн ам бүл

Булган аймагт 2019 оны байдлаар нийт хүн амын 46.7 хувь нь буюу 28.7 мянган хүн малчин өрхөд амьдарч байгаа бөгөөд нэг малчин өрхөд дунджаар 3.5 хүн амьдардаг байна.

БУЛГАН АИМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

Малчин өрхийн хүн амыг малын тооны бүлэглэлттэй харьцуулахад малын тоо ихсэх тусам өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал 100 хүртэлх малтай өрх дунджаар 3 ам бүлтэй байхад 200-аас дээш малтай өрхийн ам бүл дунджаар 4 байна.

ХҮСНЭГТ 4. МАЛЧИН ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН АМ БҮЛ, НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, МАЛЫН ТООНЫ БҮЛЭГЛЭЛТЭЭР

Малын тооны бүлэг	Малчин өрхийн тоо	Малчин өрхийн нийт хүн ам	Нэг өрхөд ногдох ам бүлийн тоо	Нэг өрхөд ногдох малын тоо	Өрхийн нэг хүнд ногдох малын тоо	Нэг өрхөд ногдох малын тоо, бодод шилжүүлснээр	Өрхийн нэг хүнд ногдох малын тоо, бодод шилжүүлснээр
Дүн	8526	29836	3.5	361.2	104.5	100.3	104.5
≤ 10	182	457	2.5	6.8	2.7	6.5	2.6
11-30	409	1109	2.7	20.9	7.7	16.7	6.2
31-50	375	994	2.7	40.4	15.2	24.9	9.4
51-100	807	2343	2.9	75.7	26.1	36.7	12.6
101-200	1510	4753	3.1	149.1	47.4	53.1	16.9
201-500	2805	10151	3.6	330.8	92.6	90.9	25.4
501-999	1801	7311	4.1	702.3	173.0	181.1	44.6
1000-1499	533	2265	4.2	1157.5	272.4	304.5	71.5
1500-2000	78	341	4.4	1662.4	380.3	427.9	97.9
2001+	26	112	4.3	2395.8	556.2	640.5	148.7

Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлт

2019 онд нийт малчин өрхийн 82.6 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 73.2 хувь нь телевизортой, 55.0 хувь нь машинтай, 48.1 хувь нь мотоциклтой, 8.7 хувь нь трактортай байна. Өмнөх онтой харьцуулвал цахилгаантай өрхийн тоо 1.7, телевизортой өрхийн тоо 0.9, машинтай өрхийн тоо 2.9, трактортай өрхийн тоо 1.1 пунктээр тус тус өссөн ба мотоциклтой өрхийн тоо 1.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 5. МАЛЧДЫН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Цахилгаантай	7432	7244	6599	6711	7043	92.2	87.3	77.6	80.9	82.6
Телевизортой	6769	5990	6137	6001	6242	84.0	72.2	72.2	72.3	73.2
Машинтай	3955	3752	4041	4326	4691	49.1	45.2	47.5	52.1	55.0
Мотоциклтой	3596	3224	3843	4090	4098	44.6	38.8	45.2	49.3	48.1
Трактортай	624	580	533	631	739	7.7	7.0	6.3	7.6	8.7

ХҮСНЭГТ 6. МАЛЧИН ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, сумаар

Сумын нэр	Малчин өрхийн тоогоор								
	цахилгаан үүсгүүртэй	телевизортой	авто машинтай	мотоциклтой	трактортой	Гар утастай	Хөлдөөгч	Угаалгын машин	
Бүгд	7043	6242	4691	4098	739	10725	2286	1461	
Булган	202	158	172	90	14	393	66	59	
Баян-Агт	514	415	271	258	1	735	180	119	
Баяннуур	213	194	190	176	1	388	112	59	
Бугат	487	429	285	265	86	536	165	136	
Бүрэгхангай	458	440	280	169	6	649	178	58	

БУЛГАН АИМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

Гурванбулаг	446	385	369	388	1	758	26	3
Дашинчилэн	288	263	289	278	9	581	87	46
Могод	430	360	247	260	0	765	142	79
Орхон	730	621	386	270	73	884	244	145
Рашаант	273	268	193	166	0	672	111	105
Сайхан	747	633	417	437	6	924	260	159
Сэлэнгэ	325	305	310	195	69	593	59	42
Тэшиг	425	419	270	250	145	583	127	110
Хангал	434	377	236	184	70	649	104	74
Хишиг-Өндөр	360	301	250	174	4	637	120	41
Хутаг-Өндөр	711	674	526	538	254	978	305	226

МАЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Малчдын тоо

Мал тооллогын 2019 оны дүнгээр 13917 малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд өмнөх оныхоос 120 малчнаар буюу 0.9 хувиар өсчээ. Малчдын тоог сумаар авч үзэхэд 2019 онд өмнөх оныхоос Баяннуур Гурванбулаг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумд 8-107-аар буурсан бол бусад сумд 6-58 малчнаар өссөн байна.

ХҮСНЭГТ 7. МАЛЧДЫН ТОО (ЭМЭГТЭЙ), сумаар

Сум	2015	2016	2017	2018	2019	2019% 2018	эмэгтэй
Булган	494	549	469	395	436	110.4	160
Баян-Агт	1139	1 124	1 152	1 068	1 094	102.4	445
Баяннуур	594	587	478	450	343	76.2	168
Бугат	754	767	819	822	836	101.7	339
Бүрэгхангай	946	992	725	715	773	108.1	280
Гурванбулаг	1165	1 174	1 093	935	903	96.6	383
Дашинчилэн	712	757	643	636	662	104.1	277
Могод	936	981	1 087	1 030	1 037	100.7	452
Орхон	1482	1 517	1 228	1 245	1 258	101.0	463
Рашаант	951	944	902	835	875	104.8	359
Сайхан	1540	1 559	1 499	1 391	1 408	101.2	616
Сэлэнгэ	530	563	562	576	584	101.4	242
Тэшиг	897	908	900	905	911	100.7	407
Хангал	778	770	775	762	807	105.9	352
Хишиг-Өндөр	797	839	857	821	787	95.9	359
Хутаг-Өндөр	1485	1 548	1 283	1 211	1 203	99.3	373
Дүн	15200	15579	14472	13797	13917	100.9	5675

Малчдын нас, хүйс

Нийт малчдын 25.6 хувь нь 15-34 насны, 60.3 хувь нь 35-59 насны, 60 ба түүнээс дээш насны малчид 14 хувийг эзэлж байна. Малтай өрхийн 79.4 хувь болох 8.5 мянган өрх нь малчин өрх байгаа бол 20.6 хувь буюу 2.2 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй малтай өрх байна.


ХҮСНЭГТ 8. МАЛЧДЫН НАСНЫ БҮЛГЭЭР

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2019% 2018
Малтай өрх	10337	10614	10685	10683	10742	100.6
Малчин өрхийн тоо	8057	8301	8499	8296	8526	102.8
Малчдын тоо	15200	15579	14472	13797	13917	100.9
үүнээс 15-34 насны	4444	4273	4074	3775	3569	94.5
35-59 насны	9245	9613	8325	8173	8389	102.6
60 ба түүнээс дээш насны	1511	1693	2055	1849	1959	105.9
Нийт малчдаас эмэгтэй	6873	7103	6091	5675	5670	99.9

БУЛГАН АИМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

Насны бүрэлдэхүүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-34 насны	29	27	26	27	26	93.7
35-аас тэтгэвэрт гарах насны	61	62	53	59	60	101.8
Тэтгэврийн	10	11	13	13	14	105.0
1 малчин өрхөд ногдох малын тоо	399	420	396	398	398	100.0


ЗУРАГ 2. МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, хувиар



Үндсэн болон туслах малчин

Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлдэг малчдын 95.8 хувь нь үндсэн малчин бол 4.2 нь туслах малчид байна. 15-24 насны малчдын 89.5 хувь нь үндсэн малчин бол 10.5 хувь нь туслах малчин байна. Нас нэмэгдэх хэрээр үндсэн малчны хувийн жин нэмэгдэж байна. 45 наснаас дээшхи насны бүлгүүдэд Үндсэн малчин 96.5-97.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧНЫ ХАРЬЦАА



Малчдын боловсролын түвшин

Малчдын боловсролын түвшинг 2019 оны байдлаар авч үзэхэд 42.1 хувь нь суурь боловсролтой, 14.9 хувь нь бага, 29.9 хувь нь бүрэн дунд, 6.5 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 5.0 хувь нь дээд, магистр боловсролтой байгаа бол 1.6 хувь нь боловсролгүй байна. Өмнөх онтой харьцуулвал боловсролгүй малчдын тоо 14 хувиар буурсан бол суурь боловсролтой малчны тоо 1 хувиар, дээд болон магистр боловсролтой малчны тоо 21 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 9. МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Насны бүлгээр	Бүгд	Боловсролын төрлөөр					Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд, магистр
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Дээд, магистр		
Бүгд	13917	223	2069	5856	4167	908	694	
15-24	845	18	87	296	343	58	43	

БУЛГАН АИМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

25-34	2724	53	344	834	1020	134	339
35-44	4217	62	632	2139	1148	81	155
45-54	3485	53	332	1577	1141	322	60
55-64	1858	23	362	776	410	229	58
65 ба түүнээс дээш	788	14	312	234	105	84	39
Дүнд эзлэхувь							
Бүгд	100	1.6	14.9	42.1	29.9	6.5	5.0
15-24	100	2.1	10.3	35.0	40.6	6.9	5.1
25-34	100	1.9	12.6	30.6	37.4	4.9	12.4
35-44	100	1.5	15.0	50.7	27.2	1.9	3.7
45-54	100	1.5	9.5	45.3	32.7	9.2	1.7
55-64	100	1.2	19.5	41.8	22.1	12.3	3.1
65 ба түүнээс дээш	100	1.8	39.6	29.7	13.3	10.7	4.9

Дээд боловсролтой малчдыг насны бүлгээр авч үзэхэд, 25-34 насныхан хамгийн өндөр буюу 48.9 хувийг эзэлж байна. Техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой малчдын 35.5 хувийг 45-54 насны малчид эзэлж байна. Бүрэн дунд боловсролтой малчдын 27.6 хувь нь 35-44 насны малчид байна.

Малчдын гэрлэлтийн байдал

Нийт малчдын 11.8 мянга буюу 84.6 хувь нь гэрлэсэн бөгөөд 80.9 хувь нь гэрлэлтээ батлуулсан, 3.7 хувь нь гэрлэлтээ батлуулаагүй байна. Харин 1.5 мянган малчин буюу 10.8 хувь нь огт гэрлээгүй, 490 малчин буюу 3.5 хувь нь бэлэвсэн, 80 буюу 0.6 хувь нь цуцалсан, 68 буюу 0.5 хувь нь гэрлэлтээ тусгаарласан байна.

ХҮСНЭГТ 10. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, насны бүлгээр

Насны бүлгээр	Бүгд	Гэрлэлтийн байдлаар					
		Огт гэрлээгүй	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэсэн батлуулаагүй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлэвсэн
Бүгд	13917	1504	11257	518	68	80	490
15-24	845	578	210	55	0	1	1
25-34	2724	497	2014	195	7	7	4
35-44	4217	229	3772	130	19	29	38
45-54	3485	134	3101	93	21	28	108
55-64	1858	54	1580	36	17	15	156
65 ба түүнээс дээш	788	12	580	9	4	0	183
Дүнд эзлэх хувь							
Бүгд	100	10.8	80.9	3.7	0.5	0.6	3.5
15-24	100	68.4	24.9	6.5	0.0	0.1	0.1
25-34	100	18.2	73.9	7.2	0.3	0.3	0.1
35-44	100	5.4	89.4	3.1	0.5	0.7	0.9
45-54	100	3.8	89.0	2.7	0.6	0.8	3.1
55-64	100	2.9	85.0	1.9	0.9	0.8	8.4
65 ба түүнээс дээш	100	1.5	73.6	1.1	0.5	0.0	23.2

15-24 насны малчдын 68.4 хувь нь огт гэрлээгүй бол 65 ба түүнээс дээш насны малчдын 23.2 хувь нь бэлэвсэн байна. Огт гэрлээгүй малчдын 86.6 хувь нь 34 хүртэлх насны малчид байна. Гэрлэсэн боловч гэрлэлтээ батлуулаагүй малчдын 79 хувь нь 25-54 насны малчид байгаа бол гэрлэлтээ тусгаарласан малчдын 83.8 хувь нь 35-64 насныхан байна. Гэрлэлтээ цуцалсан 80 малчны 90 хувь нь 35-64 насныхан байна. Бэлэвсэн 490 малчны 91.2 хувь нь 45-аас дээш насны малчид эзэлж давамгайлж байна.

Малчдын нийгмийн даатгалд хамрагдсан байдал

Мал тооллогын дүнгээр, нийт малчдын 31.7 хувь нь буюу 4.4 мянган малчин нийгмийн даатгалд хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд нийгмийн даатгал төлдөг малчдын 56.8 хувь нь эрэгтэй малчин, 43.2 хувь нь эмэгтэй малчин байна. Өмнөх онтой харьцуулвал нийгмийн даатгал төлдөг малчдын тоо 5 хувиар нэмэгдсэн байна.

Хэдийгээр малчдын нийгмийн даатгалд хамрагдалт бага байгаа хэдий ч аль насны бүлэг нь хэр хамрагддаг талаар авч үзье. 35-54 насны малчдын нийгмийн даатгал төлөлт бусад насныхнаас өндөр буюу 29.1-30.8 хувьтай байна.

Харин 15-24 насны малчдын 80.2 хувь нь нийгмийн даатгалд хамрагддаггүй буюу дөнгөж 19.8 хувь нь нийгмийн даатгалд хамрагдаж байна. Хүйсээр задлан харахад 25-34 насны эмэгтэй малчдын 24.8 хувь, эрэгтэй малчдын 24.3 хувь, 35-44 насны эмэгтэй малчдын 33.2 хувь, эрэгтэй малчдын 28.3 хувь, 45-54 насны эмэгтэй малчдын 47.8 хувь, эрэгтэй малчдын 36.5 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна.

Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал

Нийт малчдын 66.4 хувь нь буюу 9.2 мянган малчин эрүүл мэндийн даатгалд хамрагджээ. Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт өмнөх оныхоос 2.2 пунктээр буурсан байна.

Насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 51.8 хувь нь буюу 438 малчин, 25-34 насны малчдын 60.8 хувь нь буюу 1.7 мянган малчин, 35-44 насны малчдын 68.2 хувь нь буюу 2.9 мянган малчин, 45-54 насны малчдын 71.1 хувь нь буюу 2.5 мянган малчин, 55-64 насны малчдын 68.7 хувь нь буюу 1.3 мянган малчин, 65-аас дээш насны малчдын 65.9 хувь нь буюу 520 малчин эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.

Малчдын гар утас болон интернетийн хэрэглээ

2019 оны байдлаар нийт малчдын 92.2 хувь нь буюу 12.8 мянган малчин гар утас хэрэглэдэг байна. Гар утас хэрэглэгч малчдыг өмнөх онтой харьцуулахад 7 хувиар өссөн байна. Насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 92.6 хувь нь буюу 783 малчин, 25-34 насны малчдын 93.6 хувь нь буюу 2.6 мянган малчин, 35-44 насны малчдын 93.1 хувь нь буюу 3.9 мянган малчин, 45-54 насны малчдын 92.2 хувь нь буюу 3.2 мянган малчин, 55-64 насны малчдын 90.4 хувь нь буюу 1.7 мянган малчин, 65-аас дээш насны малчдын 86.3 хувь нь буюу 680 малчин гар утастай байна. Нийт малчдын 18.6 хувь нь буюу 2.6 мянган малчин интернет хэрэглэдэг байна. Өмнөх онтой харьцуулвал интернет хэрэглэгч малчид 66 хувиар өссөн байна. Насны бүлгээр авч үзвэл, 25-34, 35-54 насны малчдын 62 хувь буюу дийлэнх болж байна.

ЗУРАГ 4. МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ГАР УТАСТАЙ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР 2019 ОН, насны бүлгээр



Малчдын эзлэх хувь, насны бүлгээр

Гар утастай малчдын эзлэх хувь, насны бүлгээр

МАЛ ТЭЖЭЭВЭР, АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

2019 оны эцэст Булган аймаг нь 3641.7 толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 10.2 хувиар буюу 336.2 мянган толгойгоор өссөн байна. Төрлөөр нь харуулбал тэмээ 77 толгой буюу 5.6 хувиар, адуу 27.9 мянган толгой буюу 11.5 хувиар, үхэр 27.1 мянган толгой буюу 10.6 хувиар, хонь 145.6 мянган толгой буюу 8.2 хувиар, ямаа 135.4 мянга толгой буюу 13.2 хувиар өссөн байна. Нийт мал сүргийн 84.7 хувийг бог мал эзэлж байгаа нь өмнөх оноос бог малын дүнд эзлэх хувь 0.2 пунктээр буурсан байна. Бод мал нийт мал сүргийн 15.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос бод малын дүнд эзлэх хувь 0.2 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 11. МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
						%	зөрүү
Дүн	3223822	3485606	3361633	3305495	3641704	110.2	336209
Тэмээ	1220	1305	1360	1375	1452	105.6	77
Адуу	264274	274269	261862	244036	272020	111.5	27984
Үхэр	281576	293602	283891	255264	282391	110.6	27127
Хонь	1697841	1861270	1794411	1778224	1923834	108.2	145610
Ямаа	978911	1055160	1020109	1026596	1162007	113.2	135411

ХҮСНЭГТ 12. МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР, БОД, ХОНИН ТОЛГОЙД ШИЛЖҮҮЛСНЭЭР, сумаар

Сумын нэр	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	бодод шилжүүлснээр	ХОНИН толгойд шилжүүлснээр
		толгой.мал						
Булган	69582	0	6700	7042	31272	24568	22025	142535
Баян-Агт	321694	40	21434	23504	167619	109097	86572	557068
Баяннуур	137019	324	7390	9933	67839	51533	35557	227167
Бугат	111463	0	10566	16388	49105	35404	39564	253259
Бүрэгхангай	321449	142	19958	21127	170662	109560	83437	536444
Гурванбулаг	326638	184	18909	10773	180874	115898	74591	483103
Дашинчилэн	261860	108	15147	14359	145259	86987	64751	416270
Могод	329596	71	26602	15677	208366	78880	86973	559989
Орхон	327477	50	28861	26580	156622	115364	96040	622207
Рашаант	198039	420	12495	8960	108273	67891	48617	312700
Сайхан	373702	73	41202	19297	229108	84022	109296	709289
Сэлэнгэ	100354	0	8945	22630	40734	28045	41870	264370
Тэшиг	90123	0	9118	22113	32630	26262	39952	252770
Хангал	93547	7	7202	19026	35365	31947	36126	228722
Хишиг-Өндөр	245457	0	16970	9856	136332	82299	59835	388327
Хутаг-Өндөр	333704	33	20521	35126	163774	114250	97273	621167
Дүн	3641704	1452	272020	282391	1923834	1162007	1022479	6575386

Зураг 5. Малын тоо, сумаар, 2019




Зураг 6. Малын тоо, сумаар, 2018



2019 оны эцэст тоологдсон нийт малыг бодод шилжүүлэхэд 1022.4 мянган толгой болж өмнөх оноос 10.4 хувиар, хонин толгойд шилжүүлэхэд 6575.4 мянган толгой болж өмнөх оноос 10.5 хувиар тус тус буурсан байна.

Зураг 7. Малын тоо, өсөлт, бууралт хувиар



Малын тоог төрлөөр нь өмнөх онтой харьцуулан сумаар авч үзэхэд, адууны тоо Сэлэнгэ сум 169 толгойгоор, хонины тоо Бугат, Тэшиг сумдад 0.8-1.7 мянган толгойгоор буурсан байна. Харин бусад сумдад мал таван төрлүүдэд өссөн байна.

Улсын болон хангайн бүсэд Булган аймгийн мал сүргийн эзлэх хувь

Булган аймгийн мал сүрэг хангайн бүсийн аймгуудын нийт мал сүргийн 13.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.2 пунктээр өссөн байна. Улсын хэмжээнд 70969.3 мянган толгой мал тоологдсоны 5.1 хувийг манай аймгийн мал эзэлж байна. Нийт мал сүргийн тоогоороо улсын хэмжээнд 9-р байрт байна. Нийт мал сүргийг 5 төрлөөр нь аймагтай харьцуулвал адуун сүргийн тоогоороо 8-р байр, үхэр сүргийн тоогоороо 6-р байр, хонин сүргийн тоогоороо 8-р байр, ямаан сүргийн тоогоороо 13-р байр, тэмээн сүргийн тоогоороо 15-р байранд тус тус орж байна.

ХҮСНЭГТ 13. УЛСЫН БОЛОН ХАНГАЙН БҮСЭД МАЛ СҮРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ


Аймаг	2014	2015	2016	2017	2018	2019	<u>2019%</u> 2018
	мян.толгой						
Улсын дүн	51982.6	55979.8	61549.2	66219	66460.2	70969.3	106.8
Хангайн бүс	19283.8	20481.6	23163.7	24404.8	24323.1	26246.5	107.9
Архангай	4293.2	4457.1	5009.6	5291.8	5482.0	6167.0	112.5
Баянхонгор	3465.9	3771.9	4236.3	4587.7	4249.5	4644.9	109.3
Булган	3132.8	3223.8	3485.6	3361.6	3305.5	3641.7	110.2
Өвөрхангай	4111.5	4510.9	5208.5	5743.5	5461.3	5625.5	103.0
Хөвсгөл	4157.2	4398.1	5089.3	5297.8	5710.4	6040.4	105.8
Орхон	123.2	119.8	134.2	122.3	114.4	127.0	111.0
Хангайн бүсийн дүнд Булган аймгийн малын эзлэх хувь	16.2	15.7	15	13.8	13.6	13.8	101.5
Улсын дүнд Булган аймгийн малын эзлэх хувь	6	5.8	5.7	5.1	5.0	5.1	102.0

Малын тоогоор 2019 онд тэргүүлсэн сумдууд

Сайхан сум 348.1 мянган мал тоолуулж, нийт малын тоогоор аймагтаа тэргүүллээ. Сайхан сум 37.3 мянган адуу тоолуулж, адууны тоогоор, Хутаг-Өндөр сум 32.8 мянган үхэр тоолуулж, үхрийн тоогоор, Рашаант сум 0.3 мянган тэмээ тоолуулж, тэмээний тоогоор, Сайхан сум 216.5 мянган хонь тоолуулж, хонины тоогоор, Хутаг-Өндөр сум 108.5 мянган ямаа тоолуулж, ямааны тоогоор аймагтаа тэргүүллээ.

Зураг 8. Хамгийн их адуу тоолуулсан 5 сум

Зураг 9. Хамгийн их үхэр тоолуулсан 5 сум




Зураг 10. Хамгийн их тэмээ тоолуулсан 5 сум




Зураг 11. Хамгийн их ямаа тоолуулсан 5 сум



Зураг 12. Хамгийн их хонь тоолуулсан 5 сум



Зураг 13. Хамгийн их мал тоолуулсан 5 сум



АМИНЫ МАЛЫН ТОО

2019 онд амины малын тоо 3323.8 мянган толгой болсон нь өмнөх оноос 10.9 хувиар өссөн байна. Нийт малын 91.3 хувийг хувийн мал эзэлж байгаа нь өмнөх оноос 0.7 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 14. АМИНЫ МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР, СУМААР

Сумын нэр	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бодод шилжүүлснээр
		толгой.мал					
Булган	53640	0	4559	5167	23349	20565	16188
Баян-Агт	306303	28	20136	22044	160836	103259	81935
Баяннуур	125479	324	6897	8449	62570	47239	32165
Бугат	110028	0	10463	16054	48460	35051	38975
Бүрэгхангай	294878	142	17959	19100	158277	99400	76077
Гурванбулаг	286565	169	16898	8555	160813	100130	65025
Дашинчилэн	216262	36	12907	11034	120704	71581	53060
Могод	298684	71	23750	13873	189606	71384	78254
Орхон	320286	37	28183	25595	153264	113207	93528
Рашаант	177949	400	11142	7886	97981	60540	43526
Сайхан	355803	73	38829	18237	218716	79948	103622
Сэлэнгэ	76823	0	7447	15748	31803	21825	31224

БУЛГАН АИМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

Тэшиг	82883	0	8104	20338	29840	24601	36490
Хангал	83957	0	6639	16271	32167	28880	31881
Хишиг-Өндөр	217674	0	15065	8428	121660	72521	52835
Хутаг-Өндөр	316642	33	19205	31724	156687	108993	90717
Дүн	3323856	1313	248183	248503	1766733	1059124	925502

Малтай өрхийн бүлэглэлт

Малтай 10742 өрхийг малын тоогоор нь бүлэглэвэл, 10 хүртэлх малтай 381 өрх буюу нийт мал бүхий өрхийн 3.5 хувь, 11-30 малтай 703 өрх буюу нийт мал бүхий өрхийн 6.5 хувь, 31-50 малтай 619 өрх буюу нийт мал бүхий өрхийн 5.8 хувь, 51-100 малтай 1267 өрх буюу нийт мал бүхий өрхийн 11.7 хувь, 101-200 малтай 2037 өрх буюу нийт мал бүхий өрхийн 18.9 хувь, 201-500 малтай 3240 өрх буюу нийт мал бүхий өрхийн 30.32 хувь, 501-ээс дээш малтай 2186 өрх буюу нийт мал бүхий өрхийн 23.2 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 15. МАЛТАЙ ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МАЛЫН ТООНЫ БҮЛГЭЭР

Малын тооны бүлэг	Малтай өрхийн тоо	Малтай өрхийн малын тоо, мян.толгой	Малын төрлөөр				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүн	10742	3622845	1411	271350	279862	1911303	1158919
≤ 10	381	2486	0	213	2108	95	70
11-30	703	14455	12	1731	8077	2107	2528
31-50	619	25114	0	3001	9581	6456	6076
51-100	1267	95306	14	11045	21972	32912	29363
101-200	2037	301031	60	27209	41407	125144	107211
201-500	3240	1069681	550	78016	80865	524242	386008
501-999	1852	1297714	421	91321	70569	730358	405045
1000-1499	536	620304	344	44976	34678	367108	173198
1500-2000	81	134462	8	9099	7057	84158	34140
2001+	26	62292	2	4739	3548	38723	15280

Малтай өрхийн дийлэнх хувийг эзэлдэг 201-500 хүртэлх малтай өрхийн тоо 2019 онд 3240-д хүрч, өмнөх оныхоос 2 өрхөөр буурсан байна. 101-200 хүртэл толгой малтай өрх малтай өрхийн 18.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1 пунктээр буурсан бол, 501-ээс дээш малтай өрх 23.2 хувийг эзэлж, 2.8 пунктээр өссөн байна.

Малчин өрхийн бүлэглэлт

Амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй болсон малчин өрхийн эзэмшилд 2019 оны байдлаар нийт малын 91.3 хувь буюу 3323.8 мян.толгой мал байгаа бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад 327.5 мянга буюу 11 хувиар буурчээ. Малын төрлөөр авч үзэхэд, нийт тэмээний 90.4 хувь буюу 1.3 мянган толгой нь, адууны 91.2 хувь буюу 248.2 мянган толгой нь, үхрийн 88.0 хувь нь буюу 248.5 мянган толгой, хонины 91.8 хувь буюу 1766.7 мянган толгой нь, ямааны 91.1 хувь буюу 1059.1 мянган толгой нь малчин өрхийн эзэмшилд байна.

ХҮСНЭГТ 16. МАЛЧИН ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МАЛЫН ТООНЫ БҮЛГЭЭР

Малын тооны бүлэг	Малчин өрхийн тоо	Малчин өрхийн малын тоо, мян.толгой	Малын төрлөөр				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүн	8526	3323856	1313	248183	248503	1766733	1059124
≤ 10	182	1246	0	105	1064	47	30
11-30	409	8532	0	1189	5353	916	1074
31-50	375	15137	0	1879	6482	3433	3343
51-100	807	61079	2	7809	16387	19606	17275
101-200	1510	225098	33	21595	33537	89710	80223
201-500	2805	938967	522	68443	71887	456986	341129
501-999	1801	1264861	402	88767	68760	710907	396025
1000-1499	533	616973	344	44752	34660	365066	172151
1500-2000	78	129671	8	8905	6825	81339	32594
2001+	26	62292	2	4739	3548	38723	15280

2019 оны мал тооллогын дүнгээр 1 малчин өрхөд ногдох малын тоогоороо Дашинчилэн сум (715 толгой мал), Бүрэгхангай сум (629 толгой мал), Гурванбулаг (627 толгой мал) байгаа нь хамгийн их байна. Харин Тэшиг сум нэг малчин өрхөд ногдох малын тоогоороо (179 толгой мал) хамгийн бага байна. 2019 онд аймгийн нэг малчин өрхөд 427 толгой мал ногдож байгаа нь 7 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 17. НЭГ МАЛЧИН ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, сумаар

Сумын нэр	2015	2016	2017	2018	2019
Булган	214	233	211	258	252
Баян-Агт	436	486	458	492	513
Баяннуур	432	413	379	381	451
Бугат	226	247	229	219	217
Бүрэгхангай	599	636	582	625	629
Гурванбулаг	544	574	561	526	627
Дашинчилэн	705	679	630	629	715
Могод	591	616	528	506	539
Орхон	383	413	379	374	401
Рашаант	351	361	356	361	374
Сайхан	403	402	417	423	460
Сэлэнгэ	314	327	289	297	299
Тэшиг	166	178	178	192	179
Хангал	189	203	191	196	192
Хишиг-Өндөр	496	538	480	444	536
Хутаг-Өндөр	303	331	352	375	392
Дүн	400	420	396	398	427

СҮРГИЙН БҮТЭЦ

Сүргийн бүтцийг 2019 оны байдлаар авч үзвэл, нийт сүргийн 34.7 хувь буюу 1262.5 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 19.2 хувь буюу 698.3 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 45.3 хувь буюу 1651.4 мянган толгой нь хээлтэгч мал, 0.8 хувь буюу 29.5 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна. Малын сүрэгт эзлэх хувийг өмнөх онтой харьцуулвал төл,


өсвөр насны мал 6.1 пунктээр өссөн ба нас гүйцсэн эр мал 3.8 пунктээр, хээлтэгч мал 2.4 пунктээр буурсан бол хээлтүүлэгч өөрчлөлтгүй байна.

ХҮСНЭГТ 18. СҮРГИЙН БҮТЭЦ, сумаар

Төрөл	2014	2015	2016	2017	2018	2019
	мянган.толгой					
Бүгд	3132.8	3223.8	3485.6	3361.6	3305.4	3641.7
Төл, өсвөр насны мал	1108.5	1091.4	1170.0	1119.8	944.1	1262.5
Ажлын ба бэлтгэлийн насны эр	602.5	661.1	714.7	695.2	759.2	698.3
Хээлтэгч	1396.3	1444.8	1573.7	1520.8	1576.6	1651.4
Хээлтүүлэгч	25.5	26.5	27.2	25.8	25.5	29.5
дүнд эзлэх хувь						
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төл, өсвөр насны мал	35.4	33.9	33.6	33.3	28.6	34.7
Ажлын ба бэлтгэлийн насны эр	19.2	20.5	20.5	20.7	23.0	19.2
Хээлтэгч	44.6	44.8	45.1	45.2	47.7	45.3
Хээлтүүлэгч	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.8

Малын сүрэгт эзлэх хувийг 2009 онтой харьцуулвал төл, өсвөр насны мал 6.4 пунктээр буурсан бол нас гүйцсэн эр мал 3 пунктээр, хээлтэгч мал 3.7 пунктээр өссөн бол хээлтүүлэгч өөрчлөлтгүй байна.

ЗУРАГ 14. СҮРГИЙН БҮТЭЦ



ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

2019 оны эцэст 1651.4 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оноос 74.7 мянган толгой буюу 4.7 хувиар өссөн байна. Нийт малын 45.3 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Хээлтэгч малын тоо 2018 оноос ингэ 29 толгой буюу 5.9 хувиар, гүү 6.2 мянган толгой буюу 6.8 хувиар, үнээ 10.0 мянган толгой буюу 9.5 хувиар, эм хонь 25.7 мянган толгой буюу 2.9 хувиар, эм ямаа 32.7 мянган толгой буюу 6.6 хувиар тус тус өсжээ.

БУЛГАН АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

Мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад бод малын хувьд хээлтэгч мал сүргийн 50.0-55.0 хувь, бог малын хувьд сүргийн 60.0-65.0 хувийг эзэлж байвал зохимжтой гэж үздэг. Манай аймгийн бод малын хувьд хээлтэгч мал сүрэг 35.6-41.2, бог малын хувьд 41.1-45.6 байгаа нь нөхөн үйлдвэрлэл алдагдсан байгаа нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 19. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, төрлөөр

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
	толгой						%	зөрүү
Ингэ	446	441	460	493	488	517	105.9	29
Гүү	79428	83401	92021	91233	91837	98047	106.8	6210
Үнээ	100534	107839	115215	111096	106225	116290	109.5	10065
Эм хонь	773852	797455	879486	846474	880662	906365	102.9	25703
Эм ямаа	442036	455635	486490	471574	497442	530156	106.6	32714
Бүгд	1396296	1444771	1573672	1520870	1576654	1651375	104.7	74721

ТӨЛ БОЙЖИЛТ

2019 оны байдлаар оны эхний эх малын 84.3 хувь буюу 1329.7 мянган эх мал төллөж, өмнөх оныхоос 250.2 мянган толгой буюу 23 хувиар өсчээ. Гарсан төлийн 98.6 хувь буюу 1311.8 мянган төл бойжив. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 266.6 мянган толгой буюу 26 хувиар өсч, бойжилтын хувь 3.7 пунктээр өссөн байна. Нийт бойжсон төлийн 0.3 мянга буюу 0.02 хувь нь ботго, унага 70.0 мянга буюу 5.3 хувь, 82.5 мянга буюу 6.3 хувь нь тугал, хурга 750.8 мянга буюу 57.2 хувь, 408.1 мянга буюу 31.1 хувь нь ишиг байна. Аймгийн дүнгээр 100 эхээс 79 төл бойжуулан авсан байна.


ХҮСНЭГТ 20. БОЙЖУУЛСАН ТӨЛ, төрлөөр

Сумын нэр	2018	2019	үүнээс				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ямаа
Булган	23434	25769	0	1893	2377	12947	8552
Баян-Агт	95349	105856	10	4515	5868	63606	31857
Баяннуур	46691	43138	69	1865	2980	22703	15521
Бугат	36805	37538	0	2678	5048	19217	10595
Бүрэгхангай	90369	116612	30	4530	6017	65715	40320
Гурванбулаг	45738	129989	36	5570	3520	75321	45542
Дашинчилэн	88464	109544	42	4476	4630	65429	34967
Могод	79619	124859	19	7849	4810	82643	29538
Орхон	98587	120788	11	8348	8205	60731	43493
Рашаант	55097	76541	72	3453	2895	43826	26295
Сайхан	103198	108992	11	9847	4736	72230	22168
Сэлэнгэ	35690	37573	0	1950	5912	17775	11936
Тэшиг	32587	31888	0	2044	6920	13309	9615
Хангал	29314	34105	2	1473	5554	14591	12485
Хишиг-Өндөр	75621	94700	0	5160	3195	57500	28845
Хутаг-Өндөр	108734	113984	5	4387	9846	63293	36453
Дүн	1045297	1311876	307	70038	82513	750836	408182

ХҮСНЭГТ 21. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН төл, төрлөөр

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Бүгд	79	79	85	66	79
Ботго	69	69	57	53	59
Унага	72	72	69	54	71
Тугал	82	82	79	69	83
Хурга	80	80	87	69	83
Ямаа	80	80	86	63	77

ЗУРАГ 15. ГАРСАН ТӨЛ, БОЙЖСОН ТӨЛ, ХОРОГДСОН ТӨЛ



ХЭЭЛ ХАЯЛТ, СУВАЙРАЛТ

Эх мал хээлт хаяж сувайрах нь арчилгаа маллагаа, байгаль цаг уурын байдал, хээлтэгч хээлтүүлгийн тохиргоо зэргээс шалтгаалдаг. 2019 онд 41.2 мянган толгой хээлтэгч хээлт хаясан нь өмнөх оноос 58.5 хувиар буурсан байна.

Хээл хаясан хээлтэгч малын 44.7 хувийг эм хонь, 42.4 хувийг эм ямаа эзэлж байна. Мөн энэ онд 230.1 мянган хээлтэгч мал сувайрсан нь өмнөх оныхоос 67.8 хувиар буюу 109.1 мянган толгой малаар буурсан байна. Амйгийн дүнгээр оны эхний хээлтэгчийн 16.4 хувьтай тэнцэх эх мал хээл хаяж, сувайрнаас 271.4 мянган төл бойжуулах боломж алдсан байна.

ХҮСНЭГТ 22. ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
	толгой.мал						%	зөрүү
Ингэ	0	2	54	0	10	8	80.0	-2
Гүү	1843	1549	6382	5129	7265	3156	43.4	-4109
Үнээ	1292	1467	4195	3594	4256	2119	49.8	-2137
Эм хонь	7545	9276	24506	26341	29355	18444	62.8	-10911
Эм ямаа	8264	15951	26252	23610	29575	17521	59.2	-12054
Бүгд	18944	28245	61389	58674	70461	41248	58.5	-29213

ХҮСНЭГТ 23. СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
	толгой.мал						%	зөрүү
Ингэ	32	67	54	187	198	90	45.5	-108
Гүү	8584	11523	19296	22158	30092	18765	62.4	-11327
Үнээ	8411	10996	18172	19702	28945	21126	73.0	-7819
Эм хонь	33033	54829	84085	110171	173389	116626	67.3	-56763
Эм ямаа	27578	39733	63405	72386	106659	73554	69.0	-33105
Бүгд	77638	117148	185012	224604	339283	230161	67.8	-109122

ХҮСНЭГТ 24. ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛТЭГЧ, сумаар

Сумын нэр	2018	2019	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
			толгой.мал				
Булган	7154	6979	0	639	726	2826	2788
Баян-Агт	33175	37007	4	2893	2409	16556	15145
Баяннуур	11204	10933	35	588	754	5540	4016
Бугат	7354	9753	0	731	1092	4133	3797
Бүрэгхангай	29306	18203	18	1840	1519	10032	4794
Гурванбулаг	87856	14487	37	882	787	7704	5077
Дашинчилэн	15868	7516	13	504	685	3991	2323
Могод	53804	23754	3	1801	1224	14605	6121
Орхон	39606	24386	8	1949	2206	11812	8411
Рашаант	19844	15589	39	786	597	7999	6168
Сайхан	37429	36146	18	4217	2047	20423	9441
Сэлэнгэ	8956	8224	0	1000	2874	2624	1726
Тэшиг	4333	7742	0	676	1502	3004	2560
Хангал	6146	5573	0	769	1451	1595	1758
Хишиг-Өндөр	26373	15153	0	1065	834	7572	5682
Хутаг-Өндөр	21336	30050	9	1581	2538	14654	11268
Дүн	409744	271495	184	21921	23245	135070	91075

ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО

Аймгийн дунджаар 1 хээлтүүлэгч тэмээнд 20 хээлтэгч ногдох бол 22 хээлтэгч, 1 хээлтүүлэгч адуунд 10 хээлтэгч ногдох бол 10 хээлтүүлэгч, үхэрт 25 хээлтүүлэгч ногдох бол 38, 1 хээлтүүлэгч хонинд 50 хээлтэгч ногдох бол 85, 1 хээлтүүлэгч ямаанд 50 хээлтэгч ногдох бол 83 байна. Тооллогын дүнгээс харахад хээлтүүлэгчийн тоог нэмэгдүүлэх, эрчимжсэн МАА, цэвэр үүлдрийн мал бүртгэл, ангилалтыг ажлыг сайжруулах, МАА-н бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих түүнд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

ХҮСНЭГТ 25. ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО

Малын төрөл	Үржлийн норм	2014	2015	2016	2017	2018	2019
Ингэ	20	9	16	16	22	22	22
Гүү	10	10	10	10	10	10	10
Үнээ	25	36	35	36	41	40	38
Эм хонь	50	85	86	91	97	101	85
Эм ямаа	50	82	81	88	90	99	83

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

Оны эхний нийт малын 28.1 хувьтай тэнцэх 1024.4 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос 206.4 мянган толгой буюу 25 хувиар өссөн байна. Малтай нэг өрх дунджаар жилд 95.4 толгой малыг зах зээл болон хэрэглээнд зориулан зарцуулсан тооцоо гарч байгаа нь өмнөх онтой харьцуулахад 24.3 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 26. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019	Оны эхний малд эзлэх хувь				
Бүгд	678574	676854	1099207	818006	1024428	21.7	21.0	31.5	24.3	31.0
Тэмээ	166	146	222	211	278	13.4	12.0	17.0	15.5	20.2
Адуу	35409	37821	59277	42748	49579	14.0	14.3	21.6	16.3	20.3
Үхэр	45795	52381	81735	66004	64827	17.7	18.6	27.8	23.2	25.4
Хонь	387834	375397	615987	474445	609734	23.5	22.1	33.1	26.4	34.3
Ямаа	209370	211109	341986	234598	300010	21.6	21.6	32.4	23.0	29.2

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

2019 оны жилийн эцэст 115.9 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оныхоос 35.6 хувиар буурсан байна. Хорогдлыг төрлөөр харуулбал 15 буюу 0.01 хувь нь тэмээ, 17.2 мянга буюу 14.8 хувь нь үхэр, 43.1 мянга буюу 27.1 хувь нь ямаа байна. Аймгийн дүнгээр 115.9 мянган толгой мал хорогдсон нь оны эхний малын 3.5 хувь, нийт хорогдолд өвчний хорогдол эзэлж байна. Бог малын хорогдол өмнөх оныхоос 12 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 27. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019	2019/2018%	
	толгой.мал					%	зөрүү
Тэмээ	8	6	8	15	7	47	-8
Адуу	4502	5240	9015	17193	1744	10	-15449
Үхэр	4076	6870	10015	24322	1994	8	-22328
Хонь	37941	26603	41150	43052	14362	33	-28690
Ямаа	25955	19493	25278	31363	8086	26	-23277
Бүгд	72482	58212	85466	115945	26193	23	-89752

ХҮСНЭГТ 28. ОНЫ ЭХНИЙ МАЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Тэмээ	0.7	0.5	0.6	1.1	0.5
Адуу	1.7	2.0	3.3	6.6	0.7
Үхэр	1.4	2.4	3.4	8.6	0.8
Хонь	2.2	1.6	2.2	2.4	0.8
Ямаа	2.7	2.0	2.4	3.1	0.8
Бүгд	2.2	1.8	2.5	3.4	0.8


ХҮСНЭГТ 29. ГЭНЭТИЙН АЮУЛААР ХОРОГДСОН МАЛЫН ТОО

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Тэмээ	0	1	5	9	0
Адуу	679	713	2260	4527	272
Үхэр	580	649	2620	7029	375
Хонь	4826	2410	9602	10773	1936
Ямаа	3164	1501	7069	8775	1074
Бүгд	9249	5274	21556	31113	3657

ХҮСНЭГТ 30. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛЫН ТОО

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Тэмээ	0	1	5	9	0
Адуу	679	713	2260	4527	272
Үхэр	580	649	2620	7029	375
Хонь	4826	2410	9602	10773	1936
Ямаа	3164	1501	7069	8775	1074
Бүгд	9249	5274	21556	31113	3657

ЗУРАГ 16. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, сумаар



Хорогдлыг сумаар авч үзвэл, нийт хорогдлын дийлэнх хувийг Баян-агт сум 33.1 хувийг, Сайхан сум 14.7 хувийг, Хутаг-Өндөр сум 12.8 хувийг, Орхон сум 11.8 хувийг тус тус эзэлж байна.

ТЭЖЭЭВЭР АМЬТАД

